

**2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

2019.10.20

Дархан

№	Үүрэг даалгавар	Хариуцсан хэлтэс	Гүйцэтгэл
1.	Хотын өдрөөр нээлт хийх ажлуудыг судлаж хуваарьт оруулъя.	ХОХБТХ	Дархан хот байгуулагдсаны 58 жилийг угтаж дараах хөрөнгө оруулалтын ажлуудын нээлтийг зохион байгууллаа. Олон Улсын худалдааны төвөөс 15 дугаар баг хүртэлх 1,5 км хатуу хучилттай зам, Хараа голын гүүрнээс ширээ нуруу хүртэлх 1,709 км хатуу хучилттай авто замын нээлтийг тус тус хийв. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар буюу УИХ-ын гишүүн Б.Жавхлангийн санаачилгаар Нийтийн эзэмшлийн байруудын гадна фасад засварыг 575,7 сая төгрөгийн өртгөөр “Вилла бридж” ХХК, 15 байрны 16 блокод дээвэр засварын ажлыг “Болор эрхэст цамхаг” ХХК 89,3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.
2.	Орон нутгийн Өмчийн газраас асууя. 35,36 дугаар брак бүрэн буусан уу? Нэг байшин 9.9 сая уу? Нийт хэдэн төгрөгний өр байгаа вэ?		ОБГ-ын мөнгийг өгсөн. Өр үлдээгүй. Өөр гэрээ манай газар дээр ирээгүй. Засаг даргатай хуралдаад 140 гаруй сая төгрөгийг тодотгохоор тохирсон.
3.	Хөрөнгө оруулалтын ажлуудаа шахаж явъя. Хугацаа бага үлдсэн.	ХОХБТХ	Аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболдоор ахлуулсан ажлын хэсэг хөрөнгө оруулалтын ажлуудтай танилцаж зохих чиглэл шийдвэрийг өгсөн.
4.	Хотын өдрийн арга хэмжээний оролцоог хангаарай.	Бүгд	Хотын өдрийг угтсан арга хэмжээ, баярын хурал, баярын концертыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажилласан. Гарсан зөрчил байхгүй.
5.	Сэтгүүлийн ажлыг яаравчлах. Иргэдээс санал авах. 70371212 утсаар дан ганц биш сум, багаар нь саналыг нь авах	МТА ТЗУХ	2019 оны хийсэн онцлох ажил бүхий сэтгүүлд орох материалыг бодлогын хэлтсүүдээс нэгтгэн авч боловсруулсан. Иргэдтэй хийх уулзалтад оролцсон иргэд, хөдөлмөрчид, хотын баярын хурлын үеэр сэтгүүлийг тарааж дууссан.
6.	Малчдаа оруулаад ирсэн. Тариа хураагаагүй байдаг. Тариа руу мал орох вий дээ. Урьдчилж малчдад мэдээлэл, сэрэмжлүүлэг өг.	Хонгор сум	Мал бүхий иргэдтэй уулзаж сайтар анхааруулсан. Холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэх эрх, үүргийг танилцуулсан.
7.	МСҮТ дулаан аваагүй байна. Дулааныг нь олгуулах	ЗАА	“Бурхант хясаат” ХХК-ны удирдлагуудтай уулзаж дулааны шугамын угсралтыг 10 дугаар сарын 14-нд дуусгаж халаалтыг залгасан.

8.	Оюуны ирээдүй цогцолборт шугам хагарсан гэсэн мэдээлэл байна. Үүнийг яаралтай шийдвэрлэх	ЗАА	ДДС ТӨХК-тай гэрээ байгуулан засварын ажлыг гүйцэтгүүлж байна. Дулааны шугамын угсралтыг 10 дугаар сарын 15-нд дуусгаж халаалтыг залгасан.
9.	Шарын гол, салхит баг ХОХБТХ-тэй гэрээ байгуулах	ЗАА	<ul style="list-style-type: none"> - Шарын гол сумын эмнэлгийн дулааны шугамыг засварлах материал татан авалтыг “Дулаан шарын гол” ТӨХК хийж байгаа. Сумын ЗДТГ “Дулаан шарын гол” ТӨХК-тай гэрээ хийж баталгаажуулаад ЗАА-д ирүүлэхээр болсон. - Салхитын 11-р сургуулийн дулааны шугамын шинэчлэлтийн ажлын гэрээг байгуулсан. Уг гэрээг ХОХБТХ-т хувийг өгнө. Дулааны шугамын лотки хийх нэмэлт зардлыг тус сургуулийн дулаан хэрэглээний хэмнэлтээс гаргах боломжтой зохицуулалт хийж өгөх тухай хүсэлт тавьж байгаа.
10.	6 дугаар баг дахин төлөвлөлтийн 710 дугаар байрны ус, дулаан, цахилгааны хариуцсан байгууллагад шилжүүлэх ажлыг зохион байгуулах	ЗАА	<ul style="list-style-type: none"> - 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Дархан сумын Засаг даргын орлогч, ОНӨГ-ын мэргэжилтэн, ЗАА мэргэжилтэн, Дархан Минж ХХК-ны удирдлага, иргэдийн төлөөлөл хуралдаж ОНӨГ-аас харьяа ИСШ-ий байгууллагуудтай зөвшилцөж хөрөнгийг шилжүүлэхээр болсон.
11.	Спортын ордонд 17,0 сая төгрөг олсон. Хэн ажлыг хийх вэ?	ЗАА	<ul style="list-style-type: none"> - ДДС ТӨХК-тай гэрээ байгуулан засварын ажил хийгдэж байна.
12.	НААҮГ хог тээвэрлэлтийг хувьчлах тухай	ЗАА	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 23-ны 4-1/7297 дугаартай албан бичгийн хүрээнд Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, төсвийн үр ашиг, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Нийтийн аж ахуй үйлчилгээний газрыг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зарчмаар ажиллуулах асуудлыг судалж, бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хурлын /2019.10.15/ товыг гишүүдэд зарлаж бэлтгэл ажлыг хангасан. <ul style="list-style-type: none"> ▪ Тус ажлын хэсэг хуралдан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Өмч төсөв, санхүү эдийн засаг, гадаад бодлогын хяналтын хороотой хамтран ажиллах хүсэлтэй байгаа зохих шийдвэрийг гаргаж өгөх

			тухай албан бичгийг /Ажлын хэсгийн ахлагчийн гарын үсэгтэй Т.Ганболд/ аймгийн Иргэдийн Хурлын дарга Г.Эрдэнэбатад хүргүүлсэн.
13.	Хотын баярыг угтаж СӨХ, НААҮГ-ууд хамтран их цэвэрлэгээг зохион байгуулах	ЗАА	<ul style="list-style-type: none"> - Дархан хотын баярыг угтан Нийтийн зориулалттай орон сууцны орчны хог цэвэрлэгээний ажилд хяналт тавин ажилласан байна. - Дархан сумын ЗДТГ, НААҮГ, СӨХ-дод цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх үүрэг даалгавар өгч ажилласан.
14.	Төмөрлөгийн зуухыг аваагүй байна. Төмөрлөгт Актлах зуух байгаа. Үүнийг Хонгорт өгөх.	ЗАА	<ul style="list-style-type: none"> - Хонгор сумын “Эмт Наран” ОНӨААТҮГ “Дархан Төмөрлөгийн үйлдвэр”- ХК-с уурын зуух татан авч хашаандаа буулгасан, суурилуулах суурийн ажил хийгдэж байна. Цэцэрлэгийн өргөтгөл барих тендерт шалгарсан “Сайн констракшин” ХХК-тай ярьж уурын зуухны төрлийг тодорхой болгож захиалах компанитай холбож өгсөн. Хөрөнгийн асуудал шийдвэрлэж нийлүүлэлт хийх хугацааг хэлэхээр болсон - -
15.	Иргэдээс ирүүлсэн дулааны гомдлыг шийдвэрлэх	ЗАА	<ul style="list-style-type: none"> - Дархан сумын 11 дүгээр баг 6 дугаар хороолол 14 дүгээр байр 56 тоотын иргэн Пүрэвдоржийн паарыг нь буудуулж цэвэрлэн дулаан хэвийн болсон.
16.	Хөрөнгө оруулалтын ажлуудыг дуусгахтай холбоотой хөрөнгө оруулалттай гүйлгээнүүдийг түргэн шуурхай хийж гүйцэтгэх, СТСХ-ээс хамаарч гүйлгээ саатсан гэсэн яриа сонсохгүй. Санхүүгийн бичиг баримт бүрдүүлэлгүй яахав гэхдээ битгий саатаагаарай.	СТСХ	Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 6 арга хэмжээний зардал 240,0 сая төгрөг, ОНХСангаас 2 замын ажлын 148,0 сая төгрөг, Барилга хот байгуулалтын сайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар орж ирсэн 66,5 сая төгрөг, БСШУЯ-ны эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар орж ирсэн 199,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын гүйлгээнүүдийг цаг хугацаанд нь түргэн шуурхай хийж гүйцэтгэлээ. СТСХ-т энэ долоо хоногт хийгдээгүй үлдсэн хөрөнгө оруулалтын гүйлгээ байхгүй болно.
17.	Төсвийн орлогын биелэлт анхаарах	СТСХ	10 сард орон нутгийн төсөвт 1 тэрбум 868.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 784.7 сая төгрөг төвлөрүүлж 42.0 хувьтай , өссөнөөр 21 тэрбум 773.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 21 тэрбум 133.6 сая төгрөг төвлөрүүлж 97.1 хувьтай байна. Төсвийн орлогын жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг гаргаж төсвийн тасарч байгаа орлогын нэр төрлөөр судалгаа хийж холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

			Татварын орлого бүрдүүлэх чиглэлээр татварын өрийн үлдэгдэлтэй байгаа аж ахуйн нэгж, байгууллагад татварын байцаагч нарыг хуваарилж ажиллаж байна. Мөн 2019.10.14 ны өдөр дахин шүүхийн шийдвэр гүйцэтгэлд байгаа нийт 63 татвар төлөгчийн 1,799,2 сая төгрөг бүхий татвар төлөгч бүрийн өрийг хэрхэн барагдуулж байгаа, учирч байгаа хүндрэлүүд, хэрхэн хамтран ажиллах талаар тойрог хариуцсан гүйцэтгэгч нарыг баг хариуцсан байцаагч нартай нэг бүрчлэн тулгалт хийлгүүлэн нэмэлт мэдээлэл цуглуулах, битүүмжлэх, эрэн сурвалжлах ажлуудыг хийж байна.
18.	НААҮГ-ыг ААТБайгууллага болгох асуудалтай холбоотой хуралдах шаардлагатай байна. Ажлын хэсгийн захирамж гарсан. Хурал зохион байгуулах	СТСХ ЗА НААҮГ	НААҮГ-ыг ААТБайгууллага болгох асуудалтай холбоотой засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2019.10.15-ны 14.00 цагт хуралдсан болно.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРТУУЛ